

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР БОЛОН
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОХ
САНАМЖ БИЧИГ**

2020 оны 03 сар 13 өдөр

Улаанбаатар хот

Монгол Улс нэгдэн орсон Иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенц түүний 13 дугаар хавсралтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нэг талаас Тээврийн Прокурорын газар /цаашид Газар гэх/ нөгөө талаас Зам тээврийн яамны Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид “Алба” гэх/ хамтран ажиллах талаар дор дурьдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.

Нэг. Зорилго

1.1. Санамж бичгийн зорилго нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцын Хавсралт 13, Монгол Улсын Прокурорын тухай хууль Иргэний нисэхийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааг үр дүнтэй, хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Талууд мэдэгдэх нь

3.1. Тээврийн прокурорын газар нь Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага байна.

3.2. Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 13 р хавсралт, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9-р бүлгийн зүйл заалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага байна.

3.3. Чикагогийн Конвенцын 13 дугаар хавсралтын 3.1 дүгээр заасны дагуу агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь хэн нэгнийг буруутгах, хариуцлага тооцоход чиглэгдэхгүй бөгөөд энэ төрлийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нислэгийн аюулгүй байдлыг бүх түвшинд сайжруулах зорилготой гэдэгт талууд санал нэг байна.

3.4. Талууд Конвенцын зүйл заалтыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж болон Прокурорын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 заалтыг дээдлэн, байгууллага хоорондын харилцааны зохистой хэмжээг баримтлах, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, нээлттэй ил тод байдлыг хангах, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмыг баримтална.

3.5. Талууд агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах үед прокурор болон шинжлэн шалгагчийн үйл ажиллагааны чиг үүрэг, зарчим, байгууллага тус бүрийн хүлээх үүрэг, хариуцлага, гаргах шийдвэр хараат бус бие даасан байдал хуульчлагдсан гэдэгт санал нийлнэ.

3.6. Талууд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны үед тус тусынхаа үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр гүйцэтгэхийг эрхэмлэнэ.

Гурав. Хамтын ажиллагаа

3.1. Талууд дараах асуудал бүрээр хамтран ажиллана:

3.1.1. Мэдээлэл солилцох

3.1.2. Ослын газарт ажиллах

3.1.3. Нотлох баримт олж авах

3.1.4. Задлан болон эмгэг судлалын шинжилгээ хийх

3.1.5. Сургалт, дадлага хийх

Дөрөв.Мэдээлэл солилцох

4.1.Агаарын хөлгийн осол болсон тухай анхны мэдээллийг талууд боломжтой бол бие биедээ мэдэгдэх.

4.2.Агаарын хөлгийн ослыг шалгах, шинжлэн шалгах үед олж авсан нислэгийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн мэдээллийг талууд солилцоно.

4.3.Мэдээллийг нийтэд нээлттэй болгох хүртэл талууд харилцан солилцсон мэдээллийн нууцийг хадгална.

Тав.Ослын газарт ажиллах

5.1.Агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах үүрэг нь агаарын хөлгийг зохион бүтээсэн улс, үйлдвэрлэсэн улс, бүртгэлд авсан улс болон ашиглагч улсуудын хамтын ажиллагааны үр дүнгээс хамаардаг тул ослыг шинжлэн шалгах ажиллагаанд Олон улсын гэрээ хэлцлийн дагуу дээрх улсуудын шинжлэн шалгагч/итгэмжлэгдсэн төлөөлөгч/-д оролцдог гэдэгт талууд хүлээн зөвшөөрч дараах ажиллагаанд Прокурор дэмжлэг үзүүлнэ.

5.1.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас томилогдсон шинжлэн шалгах багийн ахлагч, ослын газрын хяналт, хориотой бүсийг тогтооход:

5.1.2.Агаарын хөлгийн осол болсон газарт тус улсаас томилогдсон шинжлэн шалгах баг болон энэ санамж бичгийн 5.1. дүгээрт заасан гадаад улсын шинжлэн шалгагчид/итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийг ослын газарт саадгүй нэвтрүүлэхэд.

5.2.Осолдсон агаарын хөлгийн үлдэгдэл болон бусад эд мөрийн баримтыг ослын газраас зөөх эсвэл ослын газрын нөхцөл байдлыг ямар нэгэн байдлаар өөрчлөх шаардлага үүсвэл талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Зургаа. Нотлох баримт олж авах

6.1.Прокурор нь ослын талаар хэргийн шаардлагатай баримт материал олж авах, Албанаас томилогдсон шинжлэн шалгагчид нь нислэгийн аюулгүй байдлыг хангах, ослын шалтгаан, нөлөөлсөн болон нөлөөлж болзошгүйг тогтоох, судалгааны баримт материал олж авах, хадгалах, ашиглахдаа өөр өөрсдийн холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хамтран ажиллана.

6.2.Прокурор болон Албаны шинжлэн шалгагчид ослын судалгаа материалын талаар харилцан хүсэлт гаргавал хууль тогтоомжоор хориглоогүй бол шаардлагатай баримтаар хангаж болно.

6.3.Осолдсон агаарын хөлгийн үлдэгдэл болон бусад эд мөрийн баримтыг ослын газраас зөөх эсвэл ослын газрын нөхцөл байдлыг ямар нэгэн байдлаар өөрчлөх шаардлага үүсвэл талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Долоо. Задлан болон эмгэг судлалын шинжилгээ хийх

7.1.Агаарын хөлгийн ослын шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг шинжлэн шалгаж тогтооход осолд өртсөн хүний биед хийх задлан, эмгэг судлалын шинжилгээ нэн чухал ач холбогдолтой гэдэгт талууд санал нэг байна. Иймд дараах ажиллагаанд Прокурор хуулиар хориглоогүй бол дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

7.1.1.Шинжлэн шалгагч шаардлагатай гэж үзсэн агаарын хөлгийн ослын улмаас үхлийн гэмтэл авсан цогцост задлан шинжилгээ хийхэд байлцах, шинжилгээний үр дүнтэй танилцах болон үр дүнгийн тайланг авах.

7.1.2.Албанаас осол, зөрчилтэй хамаарал бүхий нисгэх багийн гишүүдийн ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх эмгэг, хор судлал/эм, мансууруулах бодис г.м/-ийн шинжилгээ авхуулах, түүний үр дүнгийн тайланг авахад.

Найм. Сургалт, дадлага хийх

8.1.Агаарын хөлгийн ослын үед хамтран ажиллах сургалт, дадлагыг зохион байгуулах энэ төрлийн Олон улсын сургалт семинар болон бусад холбогдох арга хэмжээнд мэргэжилтнүүдээ оролцуулж, харилцан туршлага солилцох

Ес. Харилцаа холбоо

9.1 Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд дараах хаягаар мэдээлэл, холбоо барина.

9.1.1. Тээврийн прокурорын газар:

Утас:7012-3344

Цахим шуудан:trpo@prosecutor.mn

Хаяг:Монгол Улс, Улаанбаатар хот Баянгол дүүрэг 4-р хороо

9.1.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба:

Утас: 95953399

Цахим шуудан: aaib.gov.mn

Хаяг: Буянт-Ухаа, ХУД 21-р хороо, Улаанбаатар хот 17120

Арав. Санамж бичгийн хугацаа

10.1.Энэхүү санамж бичигт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш эхлэн гурван жилийн хугацаанд үйлчилнэ.

10.2.Энэхүү санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл цуцлах тохиолдолд энэ тухайгаа аль нэг тал нь нөгөө талдаа ажлын 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ

Арван нэг. Бусад үйл ажиллагааны зохицуулалт


11.1Энэхүү харилцан ойлголцох санамж бичгээр зохицуулагдах бүх үйл ажиллагаа нь Албаны дарга болон Тээврийн прокурорын ерөнхий газрын даргын хоорондын албан тоот болон гэрээ хэлэлцээрээр зохицуулагдана.

11.2.Энэхүү санамж бичиг нь талуудын хамтын ажиллагааны зорилгын илэрхийлэл бөгөөд үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хууль, дүрэмд нийцүүлэн санамж бичгийг байгуулсан гэж талууд ойлгоно.

11.3.Талууд хамтын ажиллагаандаа энэхүү Санамж бичгийг бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ч санамж бичигт заасан зүйлийг биелүүлээгүйгээс талуудад хариуцлага үүсэхгүй.

11.4.Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх явцад санал зөрөх, маргаантай асуудал үүсвэл талууд хамтран зөвшилцөх замаар асуудлыг шийдвэрлэнэ.

ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОР ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ Б.ОДГЭРЭЛ



АГААРЫН ХӨЛГИЙН ,ОСОЛ
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ДАРГА Ж.ЦОЛМОН

